27	Арга хэмжээ 4.1. Эх үүсвэрээ бие даасан болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэсэн, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй "Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны загвар төсөл"-ийг сумын засаг дарга нартай хамтран хэрэгжүүлэх /Улсын хэмжээнд/ /ЗГҮАХХАХТ 1.1.3.7/	Хэрэгжүүлэх сумын тоо -10, Гэрээ -10	Эх үүсвэрээ бие даасан болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэсэн, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй "Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны загвар төсөл"-ийг сумын засаг дарга нартай хамтран хэрэгжүүлэх /Улсын хэмжээнд/	"Сумдад мэргэжлээрээ ажиллаж буй төрийн албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих, ашиглах" үйл ажиллагааг цогцоор нь Сумдын засаг дарга нартай хамтран зөвлөх үйлчилгээний тусламжтай-гаар хэрэгжүүлэх ажлын үнэлгээний хороонд	Үнэлгээний хороо ХББОСЯ-ны ТНБД-ын 2024.10.21-ний өдрийн А/24 дугаар тушаалаар байгуулагдсан. - Техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулж, ТББ-т санал өгч, тендерийг зохион байгуулсан. Үүнд: - ТББ-т тусгагдсаны дагуу тендер ирүүлэхийн өмнөх уулзалтыг ХББОСЯ-ны 3 давхарт хурлын танхимд 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 11 цагт зохион байгуулсан. Уулзалтад 12 ААН оролцсон. - "8 айлын орон сууцны загвар төсөл"-ийг 10 аймгийн 10 сумдад хэрэгжүүлэхээр 10 багц тендерийг зарлаж, 2024.11.19-ний өдөр нээж, үнэлгээ хийж	2024.10.01 2024.12.15	100

			/ЗГҮАХХАХТ 1.1.3.7/	ажиллаж, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулж, ХАА-г зохион байгуулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна.	гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Тус 10 багц тендерийн шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээг байгуулаад байна. Гүйцэтгэгч нар гэрээний дагуу зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлээд байна.		
28	Арга хэмжээ 4.2. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дугаартай албан даалгаварыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох зургийн даалгаврыг боловсруулж,	Ажлын даавлагавар-6	Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дугаартай албан даалгавар	МУЕС-ын 2024.09.18-ны өдрийн 01 дугаартай албан даалгаврын хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох нэгжүүдтэй хамтран зургийн даалгаврыг боловсруулж, батлуулсан байна.	- СХОСБЗГ-тай хамтарч “Амины орон сууцны технологи дамжуулах төв”-ийг ажиллуулах ажлын даалгаврын боловсруулж батлуулсан. - Үнэлгээний хороо ХББОСЯ-ны ТНБД-ын 2024.10.21-ний өдрийн А/24 дугаар тушаалаар байгуулагдсан. Энэ хүрээнд техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан, ТББ-т санал өгч, дараах 4 тендерийг зохион байгуулсан. Үүнд: - “8 айлын орон сууцны загвар төсөл”-ийг 10 аймгийн 10 сумдад хэрэгжүүлэхээр 10 багц тендерийг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, шалгарсан гүйцэтгэгч нартай гэрээ байгуулаад байна. - “Гамшиг тэсвэртэй, эрчим хүчний алдагдал багатай, дэвшилтэт технологи бүхий “Амины орон сууцны загвар төсөл хэрэгжүүлэх тендерийг зохион байгуулж, үнэлгээ хийж байна. - “Амины орон сууцны технологи дамжуулах төв”-ийн тендерийг зохион байгуулж, шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаад байна. СХД-ийн байршил “Амины орон сууцны	2024.10.01 2024.12.15	100

					мэдээллийн төв”-ийг байгуулж үйл ажиллагааг эхлүүлж, нээлтийг 2024.12.18-ны өдөр хийсэн. - “Нэг айлын орон сууцны загвар зургийн эмхэтгэл” боловсруулах, хэвлэлийн эх бэлтгэх тендерийг зохион байгуулж байна.		
Зорилт 5. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд.							
29	Арга хэмжээ 5.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт	2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт 93.5 хувьтай.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулан, хагас жилээр тайлагнасан байна.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас жилийн байдлаар тайлагнасан байна. Биелэлт 96,2 хувьтай. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар тайлагнасан байна. Биелэлт 97,08 хувьтай.	2024.01.15 2024.06.15	100
30	Арга хэмжээ 5.2. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Тайлан, мэдээ	Тухай бүр шаардлагатай тоо баримт, мэдээллийг гарган ажилласан.	Тайлан эдээллийг тогтоосон хугацаанд нь тухай бүр гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн, тайлагнасан байна.	- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргаж, газрын хэмжээнд биелэлтийг авч нэгтгэн холбогдох газарт нь сар бүр дотоод сүлжээгээр хүргүүлсэн. - Сайд, төрийн нарийн бичгийн даргын тушал, шийдвэрийн хэрэгжилтийг гаргаж, газрын хэмжээнд биелэлтийг авч нэгтгэн холбогдох газарт нь сар бүр дотоод сүлжээгээр хүргүүлсэн. - ШСБ-ын баримт бичиг /2020-2024/ -ийн биелэлтийг газрын хэмжээнд нэгтгэн холбогдох газарт нь 2024.06.13, 2024.12.06-ны өдөр дотоод сүлжээгээр хүргүүлсэн. - "Монгол Улсыг 2021 - 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2024, 2025 онд хэрэгжүүлэх зорилтод түвшин, шалгуур үзүүлэлтийг газрын	2024.01.15 2024.06.15	100

					хэмжээнд нэгтгэн холбогдох газарт нь 2024.05.24 болон 2024.12.06-ны өдөр дотоод сүлжээгээр хүргүүлсэн.		
31	Арга хэмжээ 5.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах. Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй боловч цаг үеийн ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх.	Ёс зүй, ашиг сонирхлын зөрчилгүй байна. Үүрэг даалгаврын биелэлт	Үүрэг даалгаврын биелэлт 100 хувьтай.	Ёс зүй, ашиг сонирхлын зөрчилгүй байна. Үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллана.	- Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм болон бусад холбогдох хуульд заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй хуулийн хүрээнд ажилласан. - Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан удирдлагаас өгсөн шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, ажилласан байна	2024.01.15 2024.06.15	100
32	Арга хэмжээ 5.4. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллах, архивийн нэгж үүсгэж хүлээлгэн өгөх.	Архивт хүлээлгэн өгсөн архивын нэгж	2023 оны баримт бичгийг архивын нэгж болгон архивт хүлээлгэн өгсөн.	- Хөтлөх нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж бий болгох, архивт хүлээлгэн өгөх.	- Хөтлөх нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж бий болгох, архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэж байна. Үүнд: - 2022-2023 онд боловсуулж батлуулсан барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгавар – Боть 1; - Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, баримт материал.	2024.01.15 2024.06.15	100
33	Арга хэмжээ 5.5. Хариуцсан асуудалтай холбоотой ирүүлсэн албан бичиг төлөвлөж явуулах, ирсэн бичигт хариу төлөвлөх, хүргүүлэх. Удирдлагыг өөрийн эрхэлсэн асуудлын чиглэлээр шаардлагатай мэдээллээр хангаж, түүний ажилд мэргэжил, арга зүй, техник зохион	Албан бичиг, өргөдөл, гомдол мэдээлэл	Ирсэн албан бичиг 147, төлөвлөж явуулсан албан бичиг 85, 7 өргөдөл, гомдолыг шийдвэрлэсэн.	- Албан бичиг, өргөдөл гомдлуудыг хугацаанд нь хариу төлөвлөж, хүргүүлсэн байна.	- Өөрийн эрхэлсэн асуудлын хүрээнд удирдлагыг шаардлагатай, үнэн зөв мэдээллээр тухай бүр хангаж, ажилласан байна. - 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 75 албан бичиг хүлээн авч, 35 албан бичиг төлөвлөн холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. - 5 өргөдөл гомдлыг хүлээн авч хугацаанд нь хариу төлөвлөж, хүргүүлсэн байна.	2024.01.15 2024.06.15	100

	байгуулалтын туслалцаа үзүүлэх.						
--	---------------------------------	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Улс, орон нутгийн төсвийн болон гадаад зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зураг төсөл боловсруулах даалгаварт санал өгөх.	Санал	Санал -10	Ирүүлсэн зургийн даалгаврын төсөлд санал өгч ажилласан байна.	- Замын-Үүдчөлөөт бүсийн захирагчийн ажлын балбанаас 2024 оны 01/41 дугаар албан бичгээр ирүүлсэн “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн нэг дүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд “Замын-Үүд” чөлөөт бүсэд баригдах “Гүний гарцын шалган нэвтрүүлэх нэг цэгийн үйлчилгээний цогцолборын барилга, хатуу хог хаягдлыг ангилан ялгах дахин боловсруулах төвийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах” зургийн даалгаврын төсөлтэй танилцаж, санал боловср 2023.03.14-ний өдрийн 06/780 дугаар албан бичгээр хүргүүлсэн. - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газраас санал авахаар ирүүлсэн “Хотын төв, олон нийтийн бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгавар”, “Шинэ хархорум” хотын эрчим хүчний эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгавар”-ын төслүүдтэй танилцаж санал боловсруулж хүгүүлсэн - “Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/-ийн хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дурдсан зарим төсөл арга хэмжээний ажлын даалгаварт санал боловсруулан 2024 оны 11 дүгээр сарын 01/1379 дугаар	2024.01.15 2024.06.15	100

					албан бичгээр холбогдох байгууллагад хүргүүлсэн.		
2	Ажлын хэсгийн нарийн бичгийн даргыг орон ажиллах, тайлан, дүгнэлтийг нэгтгэж, танилцуулах	Тайлан дүгнэлт санал	2023 оны улсын төсөвт тусгагдсан төсөл арга хэмжээ.	Ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу ажиллаж холбогдох санал, дүгнэлт гаргах, танилцуулах	- Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 22-ны А/33 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь "Бүгд Найрамдах Хятад Ард Улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Ногоон нуур 1008 айлын орон сууц" төслийн Монголын талын хөрөнгөөр хэрэгжүүлэх "Ногоон нуур 1008 айлын орон сууцны барилгын дэргэдэх сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга байгууламжийн дэд бүтэц" НН1008АОСТ/202306002 дугаар төсөл арга хэмжээний хүрээнд баригдах дулаан дамжуулах төв, цахилгааны дэд өртөө түүний шугам сүлжээний ажлын гүйцэтгэлийн явцтай танилцаж дүгнэж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж ажлын хэсэгт болон яамны удирдлагуудад танилцуулан холбогдох шийдврийг гаргуулан, гэрээг сунгаж ажлыг үргэлжүүлсэн.	2023.03.20-2023.04.17	100
3	Ажлын хэсэгт гишүүнээр ажиллах	Мэдээлэл бэлтгэх	-	Ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж холбогдох мэдээлэл, санал гаргах	- Барилга хот байгуулалтын сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024.02.14-ны өдрийн 35/А/163 дугаартай тушаал, захирамжаар байгуулагдсан хамтарсан ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж, холбогдох мэдээллийг бэлтгэн ажлын хэсгийн нарийн бичгийн даргад өгсөн.	2023.02.15-2023.03.15	100
4	Үнэлгээний хороонд гишүүнээр ажиллах	Ажлын даалгавар, ТББ-т санал өгөх	2024 оны улсын төсөвт тусгагдсан төсөл арга хэмжээ.	Үнэлгээний хороонд гишүүнээр ажиллаж ажлын даалгавар, техникийн тодорхойлолт боловсруулж тендерийн баримт бичигт санал өгч ажиллах. ХАА зохион	- Үнэлгээний хороо ХББОСЯ-ны ТНБД-ын 2024.10.21-ний өдрийн А/24 дугаар тушаалаар байгуулагдсан. Энэ хүрээнд техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан, ТББ-т санал өгч, дараах 4 тендерийг зохион байгуулсан. Үүнд: - "8 айлын орон сууцны загвар төсөл"-ийг 10 аймгийн 10 сумдад хэрэгжүүлэхээр 10 багц тендер;	2024.10.01-2024.12.15	100

				байгуулахад оролцож үнэлгээ хийх.	- “Гамшиг тэсвэртэй, эрчим хүчний алдагдал багатай, дэвшилтэт технологи бүхий “Амины орон сууцны загвар төсөл хэрэгжүүлэх тендер; - “Амины орон сууцны технологи дамжуулах төв”-ийн тендер; “Нэг айлын орон сууцны загвар зургийн эмхэтгэл” боловсруулах, хэвлэлийн эх бэлтгэх тендер. - СХОСБЗГ-тай хамтарч “Амины орон сууцны технологи дамжуулах төв”-ийг ажиллуулах ажлын даалгаврын боловсруулж батлуулсан.		
5	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, холбогдох бичиг баримтын бүрдлийг хангуулах.	Сайдын тушаал, комиссын дүгнэлт.	2024 оны улсын төсөвт тусгагдсан төсөл арга хэмжээ	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан байна.	- Тус төсөл арга хэмжээний захиалагч байгууллагын Барилга байгууламжийг ашиглалтад оруулах тухай хүсэлтийн дагуу тус төсөл арга хэмжээний баримт бичгийн бүрдлийг нягтлаж, хангуулан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 118 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт баригдсан “Хилийн Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан төмөр зам”-ын доод, дээд бүтэц, ус зайлуулах хоолой, холбоо, дохиолол, ачиж буулгах терминалын талбай, гэрэлтүүлгийг ашиглалтад оруулах Комиссын бүрэлдэхүүн батлагдсан. - Тус комиссын бүрэлдэхүүн нь 2024.12.09-13-ны өдрийн хооронд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт баригдсан “Хилийн Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан төмөр зам”-ын доод, дээд бүтэц, ус зайлуулах хоолой, холбоо, дохиолол, ачиж буулгах терминалын талбай, гэрэлтүүлгийг ашиглалтад оруулах Комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу зохион байгуулж	2024.12.01 2024.12.15	100


					ажиллаж, комисын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр барилга байгууламжийг байнгын ашиглалтад авсан.		
6	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ажилчдын орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд барилга байгууламжийн өрөө тасалгааны засварын ажлыг зохион байгуулах	Үүрэг даалгавар	Яамны урсгал зардал	- Ажилчидын цайны өрөө болон 323 тоот өрөөний засалын ажлыг зохион байгуулах - Ажилчидад зориулсан цахим хурлын болон 311 тоот өрөөг 2 өрөө болгон тохижуулах ажлыг зохион байгуулах.	- Ажилчидын цайны өрөө болон 323 тоот өрөөний засалын ажлыг зохион байгуулан, иж бүрэн засварыг хийж ашиглалтад оруулсан. - Яамны баруун коридорын булан хэсгийг ашиглан шинээр ажилчидад зориулсан цахим хурлын өрөөг шинээр тохижуулж ашиглалтад оруулсан. Мөн 311 тоот өрөөг 2 өрөө болгон тохижуулсан.	2024.10.01 2024.12.01	100

Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Арга хэмжээ 1. Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх.	Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн байна.	Хуулийн төслүүд	Шинээр гарсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг судалж, санал өгөх, ажилдаа хэрэгжүүлсэн байна.	Шинээр гарч буй хууль, эрх зүйн баримт бичгүүдийг судалан танилцаж байна. Тухайлбал: - ХНХЯ-аас ирүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн төсөл болон холбогдох материалтай танилцаад дараах санал боловсруулан хүргүүлсэн. - Барилгын ерөнхий хуулийн төсөлд санал өгч ажиллсан.	2024.01.15 2024.06.15	100
3	Арга хэмжээ 3. Мэргэжлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах.	Хамрагдсан сургалтын тоо	Байгууллагын сургалтын төлөвлөгөөний дагуу дотоодын 3 сургалтад хамрагдсан. Хугацаагүй мэргэшсэн архитектор	Байгууллагын сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдах сургалтад хамрагдах, зохион байгуулж буй хурал зөвлөгөөн, сургалт болон	- Байгууллагын сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдах сургалтад хамрагдах, зохион байгуулж буй хурал зөвлөгөөн, сургалт болон бусад ажилд идэвхтэй оролцох, Мэргэжлийн байгууллагаас зарласан багц цагийн сургалтад хамрагдсан. Үүнд: - Төрийн албан зөвөлийн "7:4:10" арга зүйн сургалтын хөтөлбөрийн хүрээнд долоо хоног бүрийн пүрэв гаригт зохион байгуулладаг сургалтанд хамрагдсан. - "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн хүрээнд цэвэрлэх байгууламж баригдаж	2024.01.15 2024.06.15	100

				бусад ажилд идэвхтэй оролцох	байгаатай уялдуулан тус байгууламжуудад ажиллах инженер, техникийн ажилчдыг чадавхижуулах, цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний технологи, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлтэй танилцах богино хугацааны сургалт"-д хамрагдах зорилгоор БНХАУ-руу 10 хоногийн хугацаатай сургалтад оролцсон. Сургалт БНХАУ-ын Хөх хот, Бээжин, Хөбэй бусад хотуудад 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрүүдийн хооронд зохион байгуулагдсан.		
--	--	--	--	------------------------------------	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:
ББМБЗГ-ын шинжээч
(Албан тушаал)

 / Б.Гандолгор /
(Нэр, гарын үсэг)

.
(Огноо)

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХҮЙ, ӨРГӨХ БАЙГУУЛАМЖИЙН
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ Э.ЗОЛЗААЯАГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН
ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
Нэгжийн нэр: Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга	Төлөвлөсөн	Нийлбэр	Үнэлгээний
		хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	хугацаанд гүйцэтгэсэн байдал	оноо	багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1		2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	

Зорилт 1. “Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдүүлэх, бодлогын хэрэгжилтийг хангах” зорилтын хүрээнд” хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1	Арга хэмжээ № 1.1. Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийг үйл ажиллагааг тогтворжуулна.	30	5	35	
2	Арга хэмжээ № 1.2. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” аяныг жил бүр зохион байгуулахаар төлөвлөж, уг аяныг үр дүнтэйгээр зохион байгуулах, аяны дүнг хэлэлцэн дүгнэж, цаашид хийж хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж ажиллах.	60	10	70	
3	Арга хэмжээ № 1.3. Барилга байгууламжийн норм нормативын баримт бичгийг конвенцэд нийцүүлэх ажлын хүрээнд ажлын даалгавар, удирдамж боловсруулж, батлуулах.	60	10	70	
4	Арга хэмжээ № 1.4. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 1988 оны 167 дугаар конвенцыг сурталчилах, анхдугаар тайлангийн зөвлөмжийн тайланг ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагад хүргүүлэх.	60	10	70	
5	Арга хэмжээ № 1.5. Цахим системээр барилгын үйл ажиллагааны болон барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт тавьж, БХБСайдын тушаалаар албажуулан хүргүүлнэ. /Барилгын тухай хуулийн 33.1.15, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн	60	10	70	

Зорилт 2. “Өргөх байгууламжийн бодлого зохицуулалтын зорилтын хүрээнд” хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1	Арга хэмжээ 2.1. Лифтний техникийн зохицуулалтын баримт бичгийг боловсруулна.	60	10	70	
2	Арга хэмжээ № 2.2. Барилгын механикжуулалт, машин механизм, тоног төхөөрөмж, барилгын материалын үйлдвэрлэлийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн үйл	60	10	70	

Зорилт 3. “Холбогдох дүрэм, журам, норм, нормативын баримт бичгийг боловсруулж батлуулах, салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийг удирдлага зохицуулалт, мэргэжлийн удирдлага, зөвлөгөө, дэмжлэгээр хангах” хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1	Арга хэмжээ № 3.1. Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. I хэсэг. Ерөнхий шаардлага /БНБД 12-03-04/	60	10	70	
2	Арга хэмжээ № 3.2. Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. II хэсэг. Техникийн аюулгүй ажиллагааны дүрэм /БНБД 12-04-06/ шинэчлэх	60	10	70	
3	Арга хэмжээ № 3.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тавцант өргүүрийг угсрах аюулгүй ашиглах дүрэм	60	10	70	
4	Арга хэмжээ № 3.4. Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар /БД 12-101-05/ шинэчлэх	60	10	70	
5	Арга хэмжээ № 3.5. Барилгын материалын үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн заавар /БД 12-105-07/	60	10	70	
6	Арга хэмжээ № 3.6. Кранууд – Ачигч краны аюулгүй ажиллагааны шаардлага стандарт	60	10	70	
7	Арга хэмжээ № 3.7. Барилгын ажлын үед өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны стандарт	60	10	70	
8	Арга хэмжээ № 3.8. Барилгын ажлын үед өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны үед хэрэглэгдэх нэр, томъёо тайлбар стандарт	60	10	70	
9	Арга хэмжээ № 3.9. Барилгын гадна талд хамгаалалтын тор татах үндсэн шаардлага.	60	10	70	
10	Арга хэмжээ № 3.10. Автомашинны автомат зогсоолыг угсрах, аюулгүй ашиглах дүрэм	60	10	70	

11	Арга хэмжээ № 3.11. Барилгын инженерийн геологийн ажлын жишиг үнэ	60	10	70	
12	Арга хэмжээ № 3.12. ISO 8100-1:2019 Хүн ба ачаа тээвэрлэх лифт: Хэсэг-1 Лифт угсрах суурьлуулах аюулгүй ажиллагааны дүрэм	60	10	70	
13	Арга хэмжээ № 3.13. ISO 8100-2:2019 Хүн ба ачаа тээвэрлэх лифт: Хэсэг-2 Лифтэнд тооцоо, туршилт, хяналт, зураг төсөл хийх дүрэм	60	10	70	

Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. БХБЯ-ны ТНбД-ын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/04 дүгээр тушаал. Барилгын материалын сорилт шинжилгээний түрэгжилсэн лабораторийн тоног төхөөрөмж /Дорноговь, Замын-Үүд	60	10	70	
2	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. БХБЯ-ны ТНбД-ын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/06 дугаар тушаал. Алслагдсан хороодын иргэдийн аюулгүй байдлын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	60	10	70	
3	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. БХБЯ-ны ТНбД-ын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн Б/70 дугаар тушаал. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан, хүчин зүйлийг судалж бүртгэх, тайлагнах болон мэдээлэх үүрэг бүхий комиссын нарийн бичгийн үүрэг гүйцэтгэх.	60	10	70	
4	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. ХББООС-ын сайдын 2024 оны 73 дугаар тушаал. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах.	60	10	70	
5	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. ХББООС-ын сайдын 2024 оны 88 дугаар тушаал. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах.	60	10	70	
Дундаж оноо:				68.6	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт					
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо	
	1	2	3	4	
1	Арга хэмжээ 1. "Мэргэшсэн ижнэнер"-ийн сургалтад хамрагдана	10	1.5		
2	Арга хэмжээ 2. Холбогдох сургалтад хамрагдах	100	15		
Дундаж оноо				8	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нягжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1	Хандлага, ёс зүй	2	3
2	Дүн шинжилгээ хийх	7	
3	Асуудал шийдвэрлэх	6	
4	Хариуцлагатай байдал	6	
5	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6	Мэргэжлийн ур чадвар 1		
7	Мэргэжлийн ур чадвар 2		
8	Мэргэжлийн ур чадвар 3		
Дундаж оноо		6.6	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
1	Хандлага, ёс зүй	2
2	Багаар ажиллах	8
3	Хариуцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	68.60
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	8
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6.6
4	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо =		91.45
(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		

Үнэлгээ өгсөн:

ББМБЗГ-ын дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга


/Д.Гантулга/
(албан хаагчийн нэр)

2024.12.10 (огноо)

Үнэлгээтэй манилцаж, зөвшөөрсөн: Төрийн жинхэнэ албан хаагч:

ББМБЗГ-ын шинжээч

(албан тушаал)



/Э.Золзаал

(албан хаагчийн нэр)

Үнэлгээг хянасан:

(гарын үсэг)

(огноо)

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

ГЗУГ ДУР

(гарын үсэг)

С. Батбаяр

(албан хаагчийн нэр)

29/12/29 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга: *М*

(албан тушаал)

(гарын үсэг)

Н. Чинзориг

(албан хаагчийн нэр)

20/12/29 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн чууд захирагч

Төрийн нарийн бичгийн даргын албан

(гарын үсэг)

С. Төмөрхүү

(албан хаагчийн нэр)

(албан тушаал)

20/12/29 (огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ,
ӨРГӨХ БАЙГУУЛАМЖИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ
Э.ЗОЛЗАЯАГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдүүлэх, бодлогын хэрэгжилтийг хангах” зорилтын хүрээнд							
1.	Арга хэмжээ № 1.1. Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийг үйл ажиллагааг тогтворжуулна.	Төлөвлөгөө – 1 Хурлын тэмдэглэл – 2 Хэрэгжилтийн тайлан – 1	Төлөвлөгөө -1 Хэрэгжилтийн тайлан - 1	Төлөвлөгөө – 1 Хурлын тэмдэглэл – 1	Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэхээр холбогдох байгууллагаас санал авсан. Салбар зөвлөлийн ажлын төслөөг төслийг боловсруулсан. 2024 оны 07 дугаар сарын 10-нд Засгийн гаурын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орж дэд сайдгүй болсон. Үүнтэй холбоотой Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл ажиллаагүй. ГБХНХЯ-наас Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн	2024.01.02- 2024.12.10	50%

					үндэсний хороог шинээр зохион байгуулах, үүний дараа Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийг байгуулах чиглэлийг өгсөн.		
2.	Арга хэмжээ № 1.2. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” аяныг жил бүр зохион байгуулахаар төлөвлөж, уг аяныг үр дүнтэйгээр зохион байгуулах, аяны дүнг хэлэлцэн дүгнэж, цаашид хийж хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж ажиллах;	Албан даалгавар – 1 Хэрэгжилтийн тайлан – 1	Албан даалгавар – 1	Албан даалгавар – 1	2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр “Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн 2024” -ийг “Аюулгүй барилга, аюулгүй орчин, аюулгүй ажиллагаа” уриан дор Орхон аймгийн Эрдэнэт хотод зохион байгуулсан. Зөвлөгөөнд 21 аймаг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн 400 гаруй төлөөлөл оролцсон. 2024 оны 04 дүгээр сард “Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе” сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Аян тайланг нэгтгэсэн. Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн “Барилгын ажлын аюулгүй байдлыг хангуулах зарим арга хэмжээний тухай” 2023/3 албан даалгаврын хэрэгжилтийг хангуулахаар 2/3724 тоот албан бичгээр 21 аймаг, нийслэлд хүргүүлж, аймаг нийслэлийн засаг даргатай байгуулах гэрээний хавсралтад тусгуулсан. Хэрэгжилтийн тайлан нэгтгэж байна.	2024.04.05	100%
3.	Арга хэмжээ № 1.3.	- Батлагдсан	Анхны тайланг ОУ-	-Батлагдсан техникийн	Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 167 дугаар	2024.01.02-2024.12.05	100%

	Барилга байгууламжийн норм нормативын баримт бичгийг конвенцэд нийцүүлэх ажлын хүрээнд ажлын даалгавар, удирдамж боловсруулж, батлуулах;	техникийн даалгавар- тоо	ын Хөдөлмөрийн байгууллагад хүргүүлсэн.	даалгавар- тоо	конвенцод нийцүүлэх хүрээнд 2024 онд 12 техникийн даалгаврыг хянаж баталгаажуулсан.		
4	Арга хэмжээ № 1.4. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" 1988 оны 167 дугаар конвенцыг сурталчилах, анхдугаар тайлангийн зөвлөмжийн тайланг ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагад хүргүүлэх.	Тайлан – 1	Тайлан – 1	-	Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 167 дугаар конвенц 2020 онд нэгдэн орж, хүлээсэн үүргийнхээ дагуу дотоодын хууль тогтоомжид бүрэн туссан эсэхэд тус тус үнэлгээ хийж, 2022 онд ОУХБ-д тайланг ХНХЯ-аар дамжуулан хүргүүлсэн. ОУХБ-ын шинжээч нарын дүгнэлт хүлээгдэж байна. Барилгын салбарын норм нормативын баримт бичгийг Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 167 дугаар конвенцод нийцүүлэх хүрээнд 2024 онд 12 техникийн даалгаврыг хянаж баталгаажуулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг сайжруулах ажлын хүрээнд "Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм"-ийг ХББОСЯ-ны дэргэдэх ШУТТЗ-аар хэлэлцүүлэн, ХББОС-ын сайдын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 125 дугаар тушаалаар баталгаажуулан ХЗХЯ-нд хүргүүлсэн.	2024.01.02- 2024.12.05	100%

5	Арга хэмжээ № 1.5. Цахим системээр барилгын үйл ажиллагааны болон барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт тавьж, БХБСайдын тушаалаар албажуулан хүргүүлнэ. /Барилгын тухай хуулийн 33.1.15, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.14.6, “Гурван тулгуурт хөгжлийн бодлого” /ЗГ-ын 2018 оны 42 дугаар тогтоол/-ийн 3.6.2.1, ЗГ-ын 2019 оны 23 дугаар тогтоол, БХБЯ-ны ТНБД-ын А/45 дугаар тушаал “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.5.3.27 дахь заалт/	-Сайдын тушаал; - Тайлангийн тоо-2.	Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг ТББ-аар гүйцэтгүүлж байна.	-Сайдын тушаал; -Тайлангийн тоо-1	Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ-аас барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай 48, Монголын барилгын материалын үйлдвэрлэгчдийн холбоо ТББ-аас барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай 36 удаагийн хүсэлтийг хүлээн авч удаагийн хүсэлтийг хүлээн авч, барилгын үйл ажиллагаа шинээр эрхлэх 1309, нэмэлт ажлын төрлөөр 499, сунгах 92, дахин гэрчилгээ олгох хүсэлт гаргасан 124 хуулийн этгээдэд ХББОС-ын сайдын 80 тушаалын төслийг боловсруулж, баталгаажуулсан. Барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн суурь нөхцөл шаардага түүнд өөрчлөлт оруулах тухай асуудлаар “Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл өөрчлөлт, шинэчлэлт-2024” хэлэлцүүлэг, нээлттэй өдөрлөгийг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Монголын барилгын үндэсний ассоциаци /түншлэл/ ТББ-тай хамтран зохион байгуулж, 118 аж ахуй нэгжийн төлөөлөл оролцож, санал хүсэлтээ илэрхийлсэн. Барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн суурь нөхцөл шаардага түүнд	2024.02.10- 2024.12.10	100%
---	--	--	---	--	--	-----------------------------------	-------------

					өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж ажиллах хүсэлт гаргасан 16 байгууллагын 22 төлөөлөлийг бүртгэж, ажлын хэсгийг ХББОС-ын сайдын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 126 дугаар тушаалаар байгуулсан. БХБ-ын сайдын 2023 оны 131, 132 дугаар тушаалын дагуу “Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай” гэрээний тайланг хагас бүтэн жилээр гаргуулсан.		
Зорилт 2. Өргөх байгууламжийн бодлого зохицуулалтын зорилтын хүрээнд							
1	Арга хэмжээ № 2.1. Лифтний техникийн зохицуулалтын баримт бичгийг боловсруулна.	-СХЗГ-ын дүгнэлт - Засгийн газрын тогтоолын төсөл	Боловсруулсан төслийн хувь 30%	Боловсруулсан төслийн хувь 70%	2024.04.19-ний өдөр ажлын хэсгийг хуралдаж “Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-ын баримт бичгийн боловсруулалтын ажлын явцтай танилцаж, санал дүгнэлт өгсөн. Техникийн зохицуулалтын баримт бичгийн төслийг ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлж санал авч дууссан. “Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт” баримт бичгийг даган гарах 12 стандартын төсөлд шүүмж, редакц хийлгэж, зөвлөхөөс ирүүлсэн санал, зөвлөмж дүгнэлтийг боловсруулагчид цахимаар болон цаасаар хүргүүлсэн. Баримт бичгийн төсөлд санал авахаар холбогдох 20 байгууллагад албан бичгээр болон “Барилгын нэгдсэн мэдээллийн систем” /mcis.gov.mn/-ийн Норм,	2024.01.02-2024.12.10	100%

					норматив хэсэгт 12 стандартын төслийг 2024 оны 11 дүгээр сарын 17-д байршуулан санал авч байна. Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын төслийг "Барилгын үйлдвэрлэл, зохион байгуулалт, технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл"-өөр 2024 оны 12 дугаар сард хэлэлцүүлж, Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлэхээр бэлтгэл хангаж байна.		
2	Арга хэмжээ № 2.2. Барилгын механикжуулалт, машин механизм, тоног төхөөрөмж, барилгын материалын үйлдвэрлэлийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаанд оролцох.	Хуралд оролцох	Хуралд оролцсон - 2		Барилгын механикжуулалт, машин механизм, тоног төхөөрөмж, барилгын материалын үйлдвэрлэлийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хуралд 4 удаа оролцсон.	2024.01.02-2024.12.10	100%
Зорилт 3 . Барилга байгууламжийн техникийн зохицуулалтын баримт бичиг, барилгын норм, нормативын баримт бичиг боловсруулж, батлуулах ажлын хүрээнд: Салбарын норм, нормативын баримт бичгийг үргэлжлүүлэн болон шинээр хийж боловсруулж, батлуулах үйл ажиллагааг зохион байгуулна. /Барилгын тухай хуулийн 5.1, 33.1.2 дахь заалт/							
1	Арга хэмжээ № 3.1. Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. I хэсэг. Ерөнхий шаардлага /БНБД 12-03-04/ шинэчлэх	Баримт бичгийн төслийн боловсруулалт 60-65% хүрсэн байна.	ШУТТЗ-өөр хэлэлцүүлсэн төсөл -1	- 2023 оны ББННСангийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллана.	ШУТТЗ-ийн 2024.03.11-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. ХББОС-ын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 125 дугаар тушаалаар баталгаажуулсан.	2024.01.02-2024.12.05	100%
2	Арга хэмжээ № 3.2. Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. II хэсэг. Техникийн аюулгүй ажиллагааны дүрэм /БНБД 12-04-06/ шинэчлэх	Баримт бичгийн төслийн боловсруулалт 60-65%	Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх – 1	- 2023 оны ББННСангийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний	ШУТТЗ-ийн 2024.03.11-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. ХББОС-ын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 125 дугаар тушаалаар баталгаажуулсан.	2024.01.02-2024.06.10	100%

		хүрсэн байна.		хэрэгжилтийг хангуулан ажиллана.			
3	Арга хэмжээ № 3.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тавцант өргүүрийг угсрах аюулгүй ашиглах дүрэм	Баримт бичгийн төслийн боловсруул алт 60-65% хүрсэн байна.	Техникийн даалгавар- 1 Төслийн гүйцэтгэл – 50%	- 2023 оны ББННСангийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллана.	2022/274 дугаартай гэрээний дагуу зөвлөх үйлчилгээг гүйцэтгүүлж байна. 2023.12.22- ны өдөр 2023/258 дугаартай гэрээ байгуулж редакци хийх ажлыг эхлүүлсэн. Ирүүлсэн төсөлд 2023.12.22-ны өдөр 2023/254 дугаартай гэрээ байгуулж шүүмж хийх ажлыг эхлүүлсэн. Редакци болон шүүмж хийсэн төслийг боловсруулагчид хүргүүлсэн. Редакци болон шүүмжийн засварыг тусгасан төслийг 2024.05.21-ний өдөр ирүүлсэн. Редакц болон шүүмжийн засварыг тусгасан төслийг 2024.07.30-ны өдөр ирүүлсэн. Холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж ШУТТЗХ-аар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.	2024.01.02- 2024.12.05	100%

4	Арга хэмжээ № 3.4. Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар /БД 12-101-05/ шинэчлэх	Баримт бичгийн төслийн боловсруулалт 60-65% хүрсэн байна.	Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх – 1	- 2023 оны ББННСангийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллана.	“Барилгын үйлдвэрлэл, зохион байгуулалт, технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл”-ийн 2023.10.27-ны өдрийн хурлаар “Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. I хэсэг. Ерөнхий шаардлага” /БНБД12-03-04/ шинэчлэх ажил болон “Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм. II хэсэг. Техникийн аюулгүй ажиллагааны дүрэм” /БНБД12-04-06/ шинэчлэх ажлуудыг нэгтгэсэн “Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм” барилгын норм ба дүрмийг хэлэлцүүлж дэмжигдсэн бөгөөд энэхүү нормыг ШУТТЗ-ын хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.	2024.01.02-2024.12.05	100%
5	Арга хэмжээ № 3.5. Барилгын материалын үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн заавар /БД 12-105-07/ шинэчлэх	Баримт бичгийн төслийн боловсруулалт 60-65% хүрсэн байна.	Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх – 1	- 2023 оны ББННСангийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллана.	Барилгын материалын үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн заавар /БД 12-105-07/ боловсруулалт хийгдэж байна. Зөвлөхөөс боловсруулсан төслийг хянаж “Барилгын үйлдвэрлэл, зохион байгуулалт, технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурал”-аар 2024.11.14-нд хэлэлцүүлсэн. Хурлаар боловсруулсан нормын төсөл шаардлага хангахгүй,	2024.01.02-2024.12.04	100%

					мэргэжлийн инженер дутмаг, үг үсэг утга найруулга нь зөрүүтэй гэх мэт олон шалтгааны улмаас тус ажлыг дэмжихгүй, гэрээт ажлыг дүгнэж, энэ нормыг шинээр боловсруулж гаргах шийдвэр гарсан.		
6	Арга хэмжээ № 3.6. Кранууд – Ачигч краны аюулгүй ажиллагааны шаардлага стандарт	Баримт бичгийн төслийн боловсруулалт 100% хүрсэн байна.	Зөвлөх үйлчилгээний гэрээ – 1 Төслийн гүйцэтгэл – 30%	- 2023 оны ББННСангийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллана.	Кранууд – Ачигч краны аюулгүй ажиллагааны шаардлага стандарт боловсруулах зөвлөхтэй 2023.10.09-ний өдрийн 2023/206 дугаар гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн. Эхний төслийг 2024.03.20-ны өдөр хүлээн авч хянасан.	2024.01.02-2024.06.10	100%
7	Арга хэмжээ № 3.7. Барилгын ажлын үед өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны стандарт	Баримт бичгийн төслийн боловсруулалт 100% хүрсэн байна.	Стандартын техникийн хороонд хүргүүлсэн төсөл – 1	- 2023 оны ББННСангийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллана.	Барилгын ажлын үед өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны стандарт 2022 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 1/3961 дугаартай албан бичгээр стандартын төслийг хэлэлцүүлэхээр Стандартын техникийн хороонд хүргүүлсэн. 2024.06.20-ны өдөр СХЗГ-т хүргүүлсэн.	2024.01.02-2024.06.10	100%
8	Арга хэмжээ № 3.8. Барилгын ажлын үед өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны үед хэрэглэгдэх нэр, томъёо тайлбар стандарт	Баримт бичгийн төслийн боловсруулалт 100% хүрсэн байна.	Стандартын техникийн хороонд хүргүүлсэн төсөл – 1	- 2023 оны ББННСангийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллана.	2022 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 1/3961 дугаартай албан бичгээр стандартын төслийг хэлэлцүүлэхээр Стандартын техникийн хороонд хүргүүлсэн. Төсөл боловсруулалт хийгдэж байна.	2024.01.02-2024.06.10	100%
9	Арга хэмжээ № 3.9. Барилгын гадна талд хамгаалалтын тор татах үндсэн шаардлага.	Баримт бичгийн төслийн боловсруул	Стандартын техникийн хороонд	- 2023 оны ББННСангийн төлөвлөгөөнд тусгагдсан	Барилгын гадна талд хамгаалалтын тор татах үндсэн шаардлага боловсруулах гүйцэтгэгчтэй 2022 оны 10	2024.01.02-2024.06.10	100%

		алт 100% хүрсэн байна.	хүргүүлсэн төсөл – 1	арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллана.	дугаар сарын 26-ны өдөр 2022/242 дугаартай гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн. Зөвлөх эхний тайланг 2023 оны 3 дугаар сард ирүүлсэн.		
10	Арга хэмжээ № 3.10. Автомашины автомат зогсоолыг угсрах, аюулгүй ашиглах дүрэм	Баримт бичгийн төслийн боловсруул алт 60-65% хүрсэн байна.	Зөвлөх үйлчилгээний гэрээ – 1 Төслийн гүйцэтгэл – 30%	- 2023 оны ББННСангийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллана.	Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг 2022.11.28-ны өдөр 2022/273 дугаартай байгуулсан. Ирүүлсэн төсөлд 2023.12.22-ны өдөр 2023/256 дугаартай гэрээ байгуулж редакци хийх ажлыг эхлүүлсэн. Ирүүлсэн төсөлд 2023.12.22-ны өдөр 2023/255 дугаартай гэрээ байгуулж шүүмж хийх ажлыг эхлүүлсэн. Редакци болон шүүмжийн засварыг тусгасан төслийг 2023.05.29-ны өдөр албан бичгээр ирүүлсэн. Мэргэжлийн зөвлөлөөр 2024 оны өдрийн хурлаар хэлэлцэн дэмжигдсэн.	2024.01.02-2024.06.10	100%
11	Арга хэмжээ № 3.11. Барилгын инженерийн геологийн ажлын жишиг үнэ	Баримт бичгийн төслийн боловсруул алт 100%	ШУТТЗ-аар хэлэлцүүлсэн төсөл – 1	Сайдын тушаал – 1	2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг шинэчлэн батлах тухай” Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын 21 дүгээр тушаалын хавсралтаар “Барилгын инженер-геологи, геотехникийн ажлын жишиг үнэлгээ” /БД 81-117-24/ батлуулсан.	2024.03.25-2024.08.20	100%
12	Арга хэмжээ № 3.12. ISO 8100-1:2019 Хүн ба ачаа тээвэрлэх лифт: Хэсэг-1 Лифт угсрах суурьлуулах аюулгүй ажиллагааны дүрэм	Баримт бичгийн төслийн боловсруул алт 100%	Зөвлөх үйлчилгээний гэрээ – 1	Мэргэжлийн зөвлөлийн зөвлөмж	ISO 8100-1:2019 Хүн ба ачаа тээвэрлэх лифт: Хэсэг-1 Лифт угсрах суурьлуулах аюулгүй ажиллагааны дүрмийн төсөл СХЗГазрын дэргэдэх техникийн	2024.03.25-2024.04.03	100%

		хүрсэн байна.			хороогоор хэлэлцүүлэхээр 2024.03.11-ний өдөр хэлэлцүүлж дэмжигдсэн. СХЗГ-т 2024.04.16-ны өдөр цахимаар батлуулахаар хүргүүлсэн бөгөөд СХЗГазрын даргын 2024.08.09-ний өдрийн С/26 дугаартай тушаалаар батлагдсан.		
13	Арга хэмжээ № 3.13. ISO 8100-2:2019 Хүн ба ачаа тээвэрлэх лифт: Хэсэг-2 Лифтэнд тооцоо, туршилт, хяналт, зураг төсөл хийх дүрэм	Баримт бичгийн төслийн боловсруулалт 100% хүрсэн байна.	Зөвлөх үйлчилгээний гэрээ – 1	Мэргэжлийн зөвлөлийн зөвлөмж	ISO 8100-2:2019 Хүн ба ачаа тээвэрлэх лифт: Хэсэг-2 Лифтэнд тооцоо, туршилт, хяналт, зураг төсөл хийх дүрмийн төслийг СХЗГазрын дэргэдэх техникийн хороогоор 2024.03.11-ний өдөр хэлэлцүүлж дэмжигдсэн. СХЗГ-т 2024.04.16-ны өдөр цахимаар батлуулахаар хүргүүлсэн бөгөөд СХЗГазрын даргын 2024.08.09-ний өдрийн С/26 дугаартай тушаалаар батлагдсан.	2024.01.02-2024.08.09	100%
Зорилт 4. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд							
1	Арга хэмжээ №4.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх.	- Ирсэн бичиг шийдвэрлэлт /тоогоор/ - Төлөвлөгөө, тайлан /улирлаар, хагас бүтэн жилээр/	-	Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулна. Ирсэн бичгийг хуулийн хугацаанд, хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн.	2024.01.02-2024.06.10	100%
2	Арга хэмжээ №4.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн	- ТАХ-ын ХОМ		-ТАХ-ын ХОМ гаргана.	ТАХ-ын ХОМ-ийг 2024.02.10-ны өдөр гаргасан.	2024.01.02-2024.12.05	100%

	байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	- Бичиг баримт архивлалт -Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт		-Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.	Бусад албан байгууллагаас ирсэн 206 албан бичиг, 6 өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.		
3	Арга хэмжээ № 4.3. Барилга, хот байгуулалтын сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон бусад байгууллагуудаас байгуулсан Ажлын хэсэгт орж чиг үүргийн дагуу холбогдох байгууллагуудын ажлын хэсэгт мэргэжил арга зүгээр хангаж ажилласан байна.	Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах.	-	Хэрэгжилтийг хангаж ажиллана.	Барилга, хот байгуулалтын сайдын 1, Төрийн нарийн бичгийн даргын 5 тушаалаар ажлын хэсэгт ажилласан, ХНХС-ын тушаалаар 1 ажлын хэсэгт орж ажилласан.	2024.01.02-2024.12.05	100%
4	Арга хэмжээ № 4.4. Газарт ирсэн албан бичиг, өргөдөл гомдлын бүртгэл, барагдуулалтыг хариуцах.	Бүртгэл хөтлөх	2023 онд 69 өргөдлийг бүртгэсэн.	Бүртгэл хөтлөсөн байна.	2024 оны эхний хагас жилийн байдлаар ББМБЗГ-т ирсэн 1200 албан бичиг, 29 өргөдлийг бүртгэж холбогдох албан тушаалтанд хүргэж ажилласан.	2024.01.02-2024.12.05	100%
5	Арга хэмжээ № 4.5. Газрын хурлын тэмдэглэл хөтлөх, биелэлтийг нэгтгэн тайлагнах.	Хурлын тэмдэглэл хөтлөх	-	Тэмдэглэл хөтөлж, хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг танилцуулах.	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн болдлогын хэрэгжилтийг зохицуулах газрын 10 удаагийн хурлын тэмдэглэл бичиж, 5 хурлын биелэлтийг газрын даргад танилцуулсан.	2024.01.03-2024.12.05	100%
6	Арга хэмжээ № 4.6. “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ, “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ, “Монголын барилгын инженерүүдийн холбоо” ТББ, “Монголын барилгын материал	Тайлангийн нэгтгэл хянах,	-	гэрээний хэрэгжилтийг тайлан хянах.	“Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын БҮАТЗ-ийн хэлтсийн 2024 оны төлөвлөгөөг хянаж баталгаажуулсан.	2024.01.03-2024.12.05	90%

үйлдвэрлэгчдын холбоо” ТББ-тай байгуулсан гэрээний хэргэжилтийг тайлан хянах.						
---	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. БХБЯ-ны ТНБД-ын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/04 дүгээр тушаал. Барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лабораторийн тоног төхөөрөмж /Дорноговь, Замын-Үүд сум/	Зөвлөмж – 1	-	Бараа нийлүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулсан байх.	Барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лабораторийн тоног төхөөрөмж /Дорноговь, Замын-Үүд сум/ 2024 оны 07 дугаар сарын 29-ны өдөр тендерийг нээсэн. Тендерт 1 оролцогч оролцож 2024 оны 08 дугаар сарын 03-ны өдөр шийдвэр гаргаж НБИК ХХК хамгийн сайн гэж үнэлсэн.	2024.01.25-2024.08.03	100%
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. БХБЯ-ны ТНБД-ын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/06 дугаар тушаал. Алслагдсан хороодын иргэдийн аюулгүй байдлын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	Зөвлөмж – 1	-	Бараа нийлүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулсан байх.	Алслагдсан хороодын иргэдийн аюулгүй байдлын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ тендер шалгаруулалтыг нийт 3 удаа зохион байгуулсан. 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр нээж 2024 оны 10 дугаар сарын 14-нд хуралдаж шийдвэр гаргасан боловч захиалагч шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тул үр дүн гаргаагүй.	2024.04.01-2024.12.05	100%
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. БХБЯ-ны ТНБД-ын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн Б/70 дугаар	Үйлдвэрлэлийн осол, хурц	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг	-	2024 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргын албан	2024.03.16-2024.03.20	100%

	тушаал. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан, хүчин зүйлийг судалж бүртгэх, тайлагнах болон мэдээлэх үүрэг бүхий комиссын нарийн бичиг	хордлогыг судлан бүртгэсэн акт- 1	судлан бүртгэсэн акт- 1		үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбатын баталсан 2024 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн А/24 дугаар “Спортын арга хэмжээ зохион байгуулах тухай” тушаалын дагуу Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо Дээд салхит, Хайрхан хөгжлийн төвийн спорт зааланд гар бөмбөгийн тэмцээнд оролцож байхдаа хөлөө бэртээсэн Салбарын хяналтын газрын шинжээч Б.Цолмон холбогдох актыг батлуулсан.		
4	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. ХББОС-ын сайдын 2024 оны 73 дугаар тушаал. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах.	Комиссын акт- 1			Нийслэлийн Хан-Уул дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан “Кинг Тауэр” төслийн 66 автомашины дулаан зогсоолтой, 49 хуурай агуулахтай, 15 үйлчилгээний талбайтай, 2 давхар зоорьтой, 17 давхар бүхий 197 айлын үйлчилгээтэй орон сууцны барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2024 оны 73 дугаар тушаал комиссын тушаал, дүгнэлтийг хянаж баталгаажуулсан.	2024.10.21-2021.11.08	100%
